



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/286

Чойр

Байгууллагын нэр өөрчилж, дүрэм,
бүтэц шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Засгийн газрын 2024 оны 07 сарын 24 өдрийн "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 06 дугаар тогтоолын 6 дахь заалт, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 4.1 дэх дэд заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газар шинэчлэгдэж, яамдын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нэрийг Байгаль орчны газар болгон өөрчилсүгэй.

2.Байгууллагын нэр, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан Байгаль орчны газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, бүтэц, орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3.Байгаль орчны газрын нэрийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/148 дугаар захирамж, "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орон тоог шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 12 сарын 16-ны өдрийн А/09 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400746

Аймгийн Засаг даргын 2024 оны 09
дүгээр сарын 11-ны өдрийн 1186 дугаар
захирамжийн ... дүгээр хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Байгаль орчны газар нь /цаашид "газар" гэнэ/ салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага юм.

1.2. Байгаль орчны газар нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газрын үндсэн зорилго нь нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлэх, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, Байгаль орчны төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

1.4. Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, Улсын Их хурал, Засгийн газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, Засгийн газрын холбогдох агентлагууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон, аймгийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудтай ажлын уялдааг хангаж ажиллана.

1.5. Газар нь аймгийн хэмжээнд байгаль орчны салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, шаардлагатай мэдээллээр хангах, ажлыг зохион байгуулна.

1.6. Аймгийн байгаль орчны газрын даргыг Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж томилно.

1.7. Газрын дарга нь хяналтын ахлах байцаагч байна.

1.8. Байгаль хамгаалагчийг Засгийн газраас тогтоосон нормативын дагуу томилон ажиллуулна.

Хоёр. Бүтэц, удирдлагын зохион байгуулалт

2.1. Газар нь салбарын сайдын тушаалаар баталсан бүтцийг үндэслэн аймгийн Засаг даргын баталсан бүтэц, орон тоотойгоор ажиллана.

2.2. Газар нь мод үржүүлгийн газар болон салбарын үйл ажиллагааг мэргэжлийн үндсэн дээр эрхлэн явуулдаг, өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж, бүртгэх, үр дүн, тайлан мэдээг нэгтгэн ажиллана.

2.3. Газрын дарга аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллана.

2.4. Газрын бүтэц, орон тоо, албан хаагчдын үндсэн ба нэмэгдэл цалингийн хэмжээг зохих

хууль тогтоомжийг үндэслэн газрын дарга тогтооно.

2.5. Байгууллагын албан хаагчдыг томилох, чөлөөлөх харилцааг Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг үндэслэн, газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

2.6. Газар нь Хөдөлмөрийн дотоод журмыг албан хаагчдын саналыг үндэслэн боловсруулж, газрын даргын тушаалаар баталж, мөрдөнө.

2.7. Газар нь дотоод зохион байгуулалтын нэгжтэй байж болно.

2.8. Газрын дарга нь хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана.

2.8.1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

2.8.2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

2.8.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

2.8.4. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

2.8.5. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

2.8.6. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

2.8.7. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг салбарын хууль тогтоомжуудын хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр бүрэн хангах;

2.8.8. Газрын үйл ажиллагаанд ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, Төрийн албаны зөвлөлийн зөвшөөрсний дагуу албан тушаалын тодорхойлолтыг батлах;

2.8.9. Хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг хангуулах

2.8.10. Сум дундын ойн ангийг ерөнхий удирдлагаар хангаж ажиллах

2.8.11. Газрын албан хаагчдыг хууль журмын дагуу томилох, чөлөөлөх, шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх

2.8.12. Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах

2.8.13. Сумдын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

Гурав. Газрын үйл ажиллагааны чиглэл

3.1. Байгаль орчны чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах

3.1.1. Монгол улсын Ерөнхийлөгчөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр гаргасан зарлигийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг ханган ажиллах

3.1.2. Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих

3.1.3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах

3.1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн болон усны нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангуулах, байгаль хамгаалах, аялал жуулчлалыг

хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах;

3.1.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр эхлэх төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаархи тайланг жил бүр төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.1.6. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх;

3.1.8. Аймгийн байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жилд нэг удаа гаргах. /Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглуулах чиглэлээр/

3.2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;

3.2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын дотоод ажлыг эрхэлж, бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах, олон нийттэй харилцах, сурталчлах;

3.2.2. Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог дээшлүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежмент, байгаль хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих;

3.2.3. Байгаль орчны салбарын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах

3.2.4. Төсвийн шууд захирагчийн төсвийн төсөл, төлөвлөгөөг төлөвлөх

3.2.5. Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэл, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах.

3.2.6. Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах;

3.2.7. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах,

3.2.8. Салбарын статистик мэдээллийг нэгтгэх, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг удирдан зохицуулах;

3.2.9. Байгууллагад дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх.

3.3. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглуулах, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх:

3.3.1. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг

авах. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хангах ажлыг зохион байгуулах;

3.3.2. Байгаль Байгаль хамгаалагчдыг сонгон шалгаруулах, мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.3. Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, улсын захиалга, даалгаварт ажлын хэрэгжилтийг хангуулах;

3.3.4. Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх;

3.3.5. Орон нутгийн хэмжээнд ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд үнэлгээ хийх, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;

3.3.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөц, дурсгалт газрын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг хариуцах;

3.3.7. Аймгийн ойн сангийн ой зохион байгуулалтыг явуулж, өөрчлөлтийг тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

3.3.8. Бүс нутгийн байгаль орчинд зохицсон, зохих материаллаг бааз бүхий модлог ургамлын үржүүлгийн газар байгуулж, тарьц, суулгац ургуулах, мод сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэж орон нутгийн хэрэгцээг хангах;

3.3.9. Ховор, нэн ховор ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулах;

3.3.10. Усны нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, хаврын шар ус, борооны усыг хуримтлуулж усан сан, хөв цөөрөм байгуулах зэрэг арга хэмжээг нутаг орны байдалд тохируулан сав газрын захиргаа болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

3.3.11. Гадаргын болон газрын доорх ус авах барилга байгууламж, гүний худгуудын ашиглалтад хяналт тавих, тоолууржуулах, эзэн хариуцагчтай болгох ажлыг хариуцан, Сав газрын болон усны мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

3.3.12. Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодисын менежмент, био аюулгүй байдлын асуудлаар бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд Ус, цаг уур, орчны шинжилгээний албыг татан оролцуулах;

3.3.13. Ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг хамгаалах, түүнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан

хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

3.1. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр

3.1.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, мэдээллийг нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж, статистик мэдээлэл нэгтгэж гаргах;

3.1.2. Байгалийн нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчлэх;

3.1.3. Байгаль орчин, ногоон хөгжлийн холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах;

3.1.4. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах;

3.1.5. Аймгийн усны нөөц, түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж усны мэдээллийн сан байгуулах, гадаргын усны тооллого хийх, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандын тоо, мэдээллийг гаргах, холбогдох дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.6. Газар зүйн мэдээлэлд суурилсан мэдээллийн сан хариуцах.

Дөрөв. Газрын санхүүжилт

4.1. Газрын санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1. Салбарын төрийн захиргааны төв байгууллага, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд заасан тухайн жилд арга хэмжээнд зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгө;

4.1.2. Орон нутагт байгалийн баялгийг нөхөн сэргээх, хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан тусламж, олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

4.1.3. Орон нутгийн төсөв

Тав. Ажлын уялдаа холбоо, хүлээх хариуцлага

5.1. Газар нь салбарын яам болон яамны харьяа байгууллагууд болон доор дурдсан байгууллагуудтай харилцаж хамтран ажиллана. Үүнд:

- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар
- Усны сав газрын захиргаа
- Сум дундын Ойн анги
- Ус цаг уур, орчны шинжилгээний төв

5.2. Газрын албан хаагчид нь төсвийн шууд захирагчийн, төсвийн шууд захирагч төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

5.3. Газар нь сумдын ЗДТГ-ыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах ба холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны үр дүнг тооцох, хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ

№	Бодлогын бичигт тусгагдсан үндсэн чиг хэрэгжүүлэх зорилт	баримт болон үүргээ	Стратеги (арга зам)
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах			
Үндсэн чиг үүргийн нэр: Газар, ландшафт			
1	Зорилт 1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн өргөжүүлнэ.	сүлжээг	Газрын доорх цэнгэг усны орд газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах
2			Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх.
3			Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих
4	Зорилт 2. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлнэ.		Олон талт байгаль хамгааллын менежментийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар, ойн сан бүхий газрын хамгааллын үр ашигтай байдлыг сайжруулах
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах			
Үндсэн чиг үүргийн нэр: Усны бодлого			
5	Зорилт 1. Усны нөөцийг бохирдол, хомстлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, баталгаат ундны усаар хангана.		Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх
6			Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлж хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах
7			Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийх.
8			Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх
9			Аймгийн төвийн айл өрхүүдийг ухаалаг тоолуур, гэр хорооллын айл өрхүүдэд утаагүй түлшний хэрэглээг нэвтрүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг

		үзүүлж, агаарын бохирдлыг бууруулах
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах		
Үндсэн чиг үүргийн нэр: Ойн бодлого		
10	Зорилт 1. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Хэрлэн гол дагуу байрших байгалийн ойн санг хамгаалах
11		Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хамгаалалтыг сайжруулж, нэмэгдүүлэх
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах		
Үндсэн чиг үүргийн нэр: Биологийн олон янз байдлын бодлого		
12	Зорилт 1. Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.	Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нутагшуулж, ургамлыг тарималжуулах.
13		Ашиглалтад өртөмтгий амьтны тархац нөөцийг үе шаттайгаар хамгаалах
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах		
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын нэгдсэн удирдлага зохион байгуулалт		
14	Зорилт 1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.	Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх Төрийн албаны дотоод удирдлагын ERP системийн хэрэглээг нэмэгдүүлэх
15	Зорилт 2. Төрийн албан хаагчдыг чадавхижуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.	Аймгийн Засаг дарга болон байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэх.
16		Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.
17	Зорилт 3. Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого,	Байгаль орчны салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх

18	тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийнэ	Төрийн албан хаагчийн ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх
Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах		
Үндсэн чиг үүргийн нэр: Тогтвортой хөгжил, ногоон хөгжил		
19	Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг тодорхой хувиар бууруулна.	Тогтвортой хөгжлийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах
20	Зорилт 2. Аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөллийг бууруулах	Уул уурхай, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл болон бусад төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудит хийж, бохирдол багатай, нөөцийн хэмнэлттэй технологи нэвтрүүлж, байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах
21		Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт тавих
22	Зорилт 3. Хаягдал багатай, хэмнэлттэй цэвэр технологи, тогтвортой үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулна	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй техник, технологи, үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх
Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах		
Үндсэн чиг үүргийн нэр: Агаар, орчны бохирдол		
23	Зорилт 1. Агаарын бохирдлыг бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого судалгаа явуулж, иргэд олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, цогц арга хэмжээ авах
24		Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах
25		Агаарын чанарыг 3-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх
26	Зорилт 2. Агаар, усны чанар,	Суурьшлын бүс болон гэр хорооллын бүсэд байгаа

27	орчны бохирдлын төлөв байдлыг үнэлэх, мэдээллээр хангана.	хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах
Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах		
Үндсэн чиг үүргийн нэр: Газрын доройтол, цөлжилтийг сааруулах бодлого		
28	Зорилт 1. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг зохицуулна.	Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх
29	Зорилт 2. Газрын доройтлыг бууруулах, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулна.	Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх
30	Зорилт 3. Газрын доройтлыг бууруулах, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулна.	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавьж нөхөн сэргээлт хийлгэх
Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах		
Үндсэн чиг үүргийн нэр: Хог хаягдлын менежмент		
31	Зорилт 1. Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хууль тогтоомж боловсронгуй болгож, хэрэгжилтийг ханган эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохицуулна.	Хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулах цэг байгуулах
		Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулан, ахуйн болон туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулж, аймгийн төвд ландфилл технологийг сайжруулах
32	Зорилт 2. Аюултай хог хаягдлын менежментийг зохицуулна.	Аюултай хог хаягдлын төвлөрсөн түр хадгалах байгууламж байгуулах
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчны хяналт		
Үндсэн чиг үүргийн нэр: Хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтын чиг үүрэг		
33	Байгаль орчны салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулна.	Байгаль орчны хяналт: Газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, ой, хээрийг түймрээс хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийн

		биелэлтэд хяналт тавих;
34		Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдээс байгаль орчныг хамгаалах, сэргээн сайжруулах, засаж тохижуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр байгуулсан гэрээ, төсөл, төлөвлөгөөний биелэлт, бусад үйл ажиллагаанд хяналт тавих;
35		Хайгуул судалгаа, шинжилгээний ажлын болон байгаль орчны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих;
36		Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор тодорхойлсон болон Монгол улсын Улаан номонд орсон нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалт, нөхөн сэргээлтэд хяналт тавих;
37		Кадастрын зураглал, газрын кадастрт хяналт тавих;
38		Байгалийн баялгийг ашигласны төлбөр, хураамж, тэдгээрийг байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтэд зарцуулсан байдалд хяналт тавих;
39		Байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн барагдуулалтад хяналт тавих;
40		Байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, хөтөлбөр, гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан байдал, үнэлгээгээр заасан байгаль орчныг нөхөн сэргээх, засаж тохижуулах арга хэмжээний биелэлтэд хяналт тавих;
41		Химийн хорт бодисын үйлдвэрлэлт, экспорт, импорт, хадгалалт, худалдаалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалт, аюултай хог хаягдлын экспорт, импорт, хил дамжуулан тээвэрлэлтэд хяналт тавих;
42		Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад хяналт тавих;

43		Байгаль орчны бохирдолд хяналт тавих;
44		Суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалж эрүүл ахуйн бүс тогтоосон байдалд хяналт тавих;
45		Байгаль орчны даацын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих
46		Агаар, ус, хөрсөн дэх хими, биологийн хортой бодисын хүлцэх хэм хэмжээ, байгаль орчинд хаяж болох хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих;

Аймгийн Засаг даргын 2024 оны 09
дүгээр сарын 11-ны өдрийн 1186 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
1	2	3	4
1	Газрын дарга	T3-4	1
2	Нягтлан бодогч	TУ-8	1
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	T3-7	1
4	Байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-8	1
5	Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
6	Ой, цөлжилт, биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
7	Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газар, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
8	Сүмбэр сумын байгаль хамгаалагч	T3-9	1
9	Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав	TУ-5	1
10	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан харуул хамгаалалтын ахлагч, байгаль хамгаалагч	TУ-3	1
11	Жолооч	TУ-3	1
12	Үйлчлэгч	TУ-1	1